

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны III улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Агуулга

Хүснэгтийн жагсаалт	3
Зургийн жагсаалт.....	3
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН	4
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	5
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	6
Батлан даалт, байршил.....	7
Батлан даалт, зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэл.....	8
Зээлдүүлэгч болон батлан даалтын эх үүсвэр.....	9
Зээлийн болон батлан даалтын чанар.....	10
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	12
САНАЛ, ДҮГНЭЛТ	13

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Батлан даалтын хүсэлтийн тоо.....	6
Хүснэгт 2 Зээл, батлан даалтын хэмжээ, тоо (дүүргээр).....	7
Хүснэгт 3 Зээл, батлан даалтын хэмжээ, тоо (аймгаар).....	8
Хүснэгт 4 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	12

Зургийн жагсаалт

Зураг 1 Нийт хөрөнгө (тэр.төг)	5
Зураг 2 Эх үүсвэрийн бүтэц (хувиар).....	5
Зураг 3 Нийт орлого, цэвэр ашиг (тэр.төг)	5
Зураг 4 Нийт орлого, зардал (тэр.төг)	5
Зураг 5 Зээл, батлан даалтын үлдэгдэл (тэр.төг).....	6
Зураг 6 Нэг батлан даалтын дундаж хэмжээ (сая.төг)	6
Зураг 7 Батлан даалтын хэмжээ, тоо (бүс нутгаар).....	7
Зураг 8 Батлан даалтын бүтэц (үйл ажиллагааны чиглэлээр).....	8
Зураг 9 Батлан даалтын хэмжээ (банкаар)	9
Зураг 10 Батлан даалтын бүтэц (эх үүсвэрээр).....	9
Зураг 11 Зээлийн чанар (хувиар)	10
Зураг 12 Батлан даалтын чанар (хувиар)	10
Зураг 13 Чанаргүй батлан даалтын хувь, зээлдэгчдийн тоо.....	10
Зураг 14 Үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын хэмжээ (тэр.төг).....	11
Зураг 15 Төлөгдсөн авлагын хэмжээ (тэр.төг).....	11

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталж, 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Зээлийн батлан даалтын сан байгуулагдсан. Зээлийн батлан даалтын сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, хуулийн этгээд, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.

Засгийн газраас хэрэгжүүлж буй төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд 2021 онд Улсын Их Хурлаас тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 9 дүгээр зүйлийн 9.1.3-т “төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах” гэж заасан. Үүний дагуу 2023 оноос эхлэн 21 аймаг болон Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд банк, санхүүгийн байгууллагаас орон сууцны ипотекийн 6 хувийн хүүтэй зээл авахыг хүссэн, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн дутагдалтай этгээдэд урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргаж эхэлсэн.


Мөн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-т “уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хоршооны гишүүн малчинд урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 100 хүртэлх хувьд батлан даалт гаргах.” гэж нэмсэн. Үүний дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын 2.2.2 дахь заалтыг “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хоршооны гишүүн малчинд гаргах зээлийн батлан даалтын хэмжээ нь банк санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 100 хүртэлх хувьд, бусад төрлийн нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд гаргах зээлийн батлан даалтын хэмжээ нь банк санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 60 хүртэл хувь буюу сангийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй” гэж хуульд нийцүүлж өөрчлөн найруулсан.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолоор Зээлийн батлан даалтын сангийн дүрэмд 3 заалтыг өөрчлөн найруулахаар, 9 заалтад нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэж, Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлтээ ирүүлсэн ба Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлээр Зээлийн батлан даалтын сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


2024 оны III улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 311.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.8 хувиар буюу 53.7 тэрбум төгрөгөөр өссөн ба үүнд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт голлон нөлөөлж байна.

Зураг 1 Нийт хөрөнгө (тэр.төг)




Тайлант үеийн Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг бүтцээр нь задалж үзвэл 66.6 хувийг өр төлбөр, 33.4 хувийг цэвэр хөрөнгө бүрдүүлж байна. Нийт өр төлбөрийн 2.9 хувь нь богино хугацаат өр төлбөр бол үлдсэн 97.1 хувь нь урт хугацаат зээл, урт хугацаат зээлийн хүүгийн өглөг байна.

Зураг 2 Эх үүсвэрийн бүтэц (хувиар)




Тайлант үеийн нийт орлого 21.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.3 дахин их буюу 12.1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Харин цэвэр ашгийн хэмжээ 15.1 тэрбум төгрөгийг өмнөх оны дүнтэй харьцуулахад 3.6 дахин их буюу 10.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зураг 3 Нийт орлого, цэвэр ашиг (тэр.төг)



Нийт орлогын 75.2 хувийг хадгаламжийн хүүгийн орлого, 24.8 хувийг батлан даалтын шимтгэл, хураамжийн орлого бүрдүүлж байгаа бол нийт зардлын 55.3 хувийг төсөл хэрэгжүүлсний зардал, 44.7 хувийг ерөнхий удирдлагын зардал тус тус эзэлж байна.


Зураг 4 Нийт орлого, зардал (тэр.төг)



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны III улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сантай 11 банк, 5 банк бус санхүүгийн байгууллага хамтран ажиллах гэрээтэй бөгөөд тайлант хугацаанд нэр бүхий 8 банкны 10,774 зээлдэгчдэд 306.3 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Зураг 5 Зээл, батлан даалтын үлдэгдэл (тэр.төг)



Тайлант үеийн байдлаарх нийт батлан даасан зээлийн үлдэгдэл 673.9 тэрбум төгрөг байгаа нь 2023 оны мөн үеэс 3.9 дахин, батлан даалтын үлдэгдэл 384.8 тэрбум төгрөг байгаа нь 4.3 дахин өссөн үзүүлэлт бөгөөд нийт зээлийн үлдэгдлийн 57.1 хувийг Зээлийн батлан даалтын сангаас батлан даасан байна.


2024 оны III улирлын байдлаар батлан даалтын нийт 10,775 хүсэлт ирүүлснийг 100 хувь батлан даах шийдвэр гарсан ч тайлант хугацаанд 10,774 зээлдэгчийн зээл олгогдож, батлан даалт нь гарсан байна. Тайлант үеийн нийт ирүүлсэн хүсэлтийн тоог 2023 оны мөн үетэй харьцуулахад 53.4 дахин их байгаа ба үүнд Монгол Улсын Засгийн газраас баталсан “Төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлого” болон “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд батлан даалт гаргуулах сонирхолтой иргэдийн хүсэлт голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1 Батлан даалтын хүсэлтийн тоо

Батлан даалтын хүсэлт	2020.III	2021.III	2022.III	2023.III	2024.III
Ирүүлсэн хүсэлтийн тоо	47	319	56	202	10,775
Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	26	236	31	155	10,775
Зөвшөөрөгдсөн хүсэлт	55%	74%	55%	77%	100%

2024 он гарснаас хойш нийт 10,774 зээлдэгчийн 515.1 тэрбум төгрөгийн зээлд 306.3 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь 2023 оны мөн үеэс 9.4 дахин өссөн байна. 2024 онд гаргасан нэг батлан даалтын дундаж хэмжээг тооцвол 28.4 сая байгаа нь өмнөх 4 жилийн дундажтай харьцуулахад 8.1 дахин бага үзүүлэлт юм. Үүнд хоршооны гишүүн малчдад гаргасан батлан даалт голлон нөлөөлж байгаа ба нэг малчинд олгосон дундаж зээлийн хэмжээ 33.0 сая төгрөг, батлан даалтын дүн 24.7 сая төгрөг байна.

Зураг 6 Нэг батлан даалтын дундаж хэмжээ (сая.төг)



Тайлант үеийн хугацаанд Улаанбаатар хотын 134 зээлдэгчийн 70.4 тэрбум төгрөгийн зээлд 37.0 тэрбум төгрөгийн, орон нутгийн 10,640 зээлдэгчийн 444.7 тэрбум төгрөгийн зээлд 269.3 тэрбум төгрөгийн батлан даалт тус тус гаргасан байна.

Батлан даалт, байршил

2024 оны III улирлын байдлаар нийслэлийн дараах 8 дүүрэгт батлан даалт гаргасан ба Баянзүрх болон Хан-Уул дүүргүүдэд хамгийн их буюу 10.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний батлан даалт гаргасан бол Налайх дүүрэгт хамгийн бага буюу 61 сая төгрөгийн батлан даалт гаргажээ. Нийслэлийн 134 зээлдэгчийн 25 зээлдэгч нь ипотекийн зээл авсан иргэд, 15 зээлдэгч нь “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий малчид бол үлдсэн 94 зээлдэгч нь үйлдвэрлэл, үйлчилгээ болон бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд байна.

Хүснэгт 2 Зээл, батлан даалтын хэмжээ, тоо (дүүргээр)

Дүүрэг	Зээлийн дүн /сая.төг/	Батлан даалтын дүн /сая.төг/	Батлан даалтын тоо
Багануур	2,522.9	539.6	26
Баянгол	12,092.4	6,285.3	21
Баянзүрх	19,312.7	10,753.8	29
Налайх	194.2	60.8	2
Сүхбаатар	6,112.2	3,467.5	7
Сонгинохайрхан	5,638.0	2,767.0	14
Хан-Уул	18,766.2	10,377.5	27
Чингэлтэй	5,810.0	2,795.0	8
Улаанбаатар	70,448.6	37,046.5	134

Тайлант хугацаанд гаргасан батлан даалтыг бүс нутгаар задалж үзвэл хангайн бүсэд хамгийн их буюу 3,971 зээлдэгчийн 165.7 тэрбум төгрөгийн зээлд 95.7 тэрбум төгрөгийн батлан даалт, зүүн бүсэд хамгийн бага буюу 1,126 зээлдэгчийн 54.6 тэрбум төгрөгийн зээлд 30.8 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна. Орон нутагт гаргасан нийт батлан даалтын дүнгийн 4.3 хувь нь хуулийн этгээдэд, үлдсэн 95.7 хувь нь иргэдэд гаргасан батлан даалт байна.

Зураг 7 Батлан даалтын хэмжээ, тоо (бүс нутгаар)



Батлан даалтад хамрагдсан орон нутгийн 10,640 зээлдэгчийн 269.3 тэрбум төгрөгийн батлан даалтын 88.5 хувь буюу 238.1 тэрбум төгрөг нь 9,661 хоршооны малчдын зээлд, 7.3 хувь буюу 19.7 тэрбум төгрөг нь 937 иргэний ипотекийн зээлд, 4.2 хувь буюу 11.5 тэрбум төгрөг нь 42 хуулийн этгээдийн бизнесийн зээлд гаргасан батлан даалт байна.

Хүснэгт 3 Зээл, батлан даалтын хэмжээ, тоо (аймгаар)

Аймаг	Зээлийн дүн /сая.төг/	Батлан даалтын дүн /сая.төг/	Батлан даалтын тоо
Архангай аймаг	39,210.7	29,106.7	1,268
Баян-Өлгий аймаг	510.2	169.1	7
Баянхонгор аймаг	37,257.5	23,582.3	1,030
Булган аймаг	19,651.5	11,533.0	458
Говь-Алтай аймаг	43,182.9	26,875.1	1,184
Говьсүмбэр аймаг	4,994.0	3,422.7	108
Дархан-Уул аймаг	5,761	2,149.9	85
Дорноговь аймаг	7,219.4	4,709.5	160
Дорнод аймаг	18,186.7	7,853.7	296
Дундговь аймаг	16,665.0	12,195.2	448
Завхан аймаг	22,193.8	13,655.7	587
Орхон аймаг	23,173.9	7,270.2	251
Өвөрхангай аймаг	28,618.6	15,074.2	583
Өмнөговь аймаг	10,671.9	5,951.1	123
Сүхбаатар аймаг	16,043.6	8,243.8	327
Сэлэнгэ аймаг	22,784.2	13,547.4	532
Төв аймаг	30,187.9	20,527.6	739
Увс аймаг	32,057.0	22,018.9	825
Ховд аймаг	28,116.8	17,480.7	745
Хөвсгөл аймаг	17,774.9	9,177.4	381
Хэнтий аймаг	20,402.4	14,713.5	503
Нийт	444,663.6	269,257.5	10,640

Батлан даалт, зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэл

2024 оны III улирлын байдлаар нийт гаргасан батлан даалтын 77.9 хувийг Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий малчид, 6.3 хувийг бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа, 3.1 хувийг боловсруулах үйлдвэр, 1.4 хувийг эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, 1.0 хувийг хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйн үйл ажиллагаа, үлдсэн 10.3 хувийг бусад салбар тус тус эзэлж байна.

Зураг 8 Батлан даалтын бүтэц (үйл ажиллагааны чиглэлээр)

Шинэ хоршоо
хөдөлгөөний малчид



77.9%

Эрүүл мэнд ба
Нийгмийн халамж



1.4%

Бөөний болон
жижиглэн худалдаа



6.3%

Хөдөө болон
ойн аж ахуй



1.0%

Боловсруулах
үйлдвэр



3.1%

Бусад




10.3%

Зээлдүүлэгч болон батлан даалтын эх үүсвэр


Тайлант хугацаанд доорх 8 арилжааны банкны зээлд батлан даалт гаргасан ба Төрийн банкны 308.7 тэрбум төгрөгийн зээлд 204.5 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь нийт батлан даалтын 66.8 хувийг эзэлж байна. Хаан банкны 119.6 тэрбум төгрөгийн зээлд 61.7 тэрбум төгрөгийн, Худалдаа хөгжлийн банкны 36.1 тэрбум төгрөгийн зээлд 15.6 тэрбум төгрөгийн, Капитрон банкны 26.2 тэрбум төгрөгийн зээлд 14.3 тэрбум төгрөгийн, Богд банк, Голомт банк, Хас банк, Ариг банк зэрэг санхүүгийн байгууллагуудын 24.4 тэрбум төгрөгийн зээлд 10.1 тэрбум төгрөгийн батлан даалт тус тус гаргасан байна. Хамгийн их батлан даалттай зээл олгосон Төрийн банкны хувьд хоршооны гишүүн малчдад олгосон зээлийн батлан даалтын хэмжээ 190.4 тэрбум төгрөг байгаа нь тухайн банканд гаргасан батлан даалтын 93.1 хувийг эзэлж байна.

Зураг 9 Батлан даалтын хэмжээ (банкаар)



Эх үүсвэрийн хувьд авч үзвэл тайлант үеийн хугацаанд гаргасан нийт батлан даалтын 77.9 хувь буюу 238.6 тэрбум төгрөгийг “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бол 13.7 хувийг Азийн хөгжлийн банкны МОН-3338 төсөл, 6.6 хувийг ипотека, үлдсэн 1.8 хувийг Азийн хөгжлийн банк-Эмэгтэй бизнес, Жайка, Ногоон зээл, Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл зэрэг бусад эх үүсвэрээс тус тус санхүүжүүлжээ.

Зураг 10 Батлан даалтын бүтэц (эх үүсвэрээр)



Зээлийн болон батлан даалтын чанар

Батлан даасан нийт зээлийн үлдэгдлийг харвал нийт 11,339 зээлдэгчээс 11,270 зээлдэгчийн 650.7 тэрбум төгрөгийн зээл хэвийн ангилалд байгаа нь нийт зээлийн багцын 96.6 хувийг эзэлж байна. Ангилал буурсан зээлийн хувьд 5 зээлдэгчийн 3.1 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 64 зээлдэгчийн 20.1 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийн хувьд нэг зээлдэгчийн хугацаа хэтэрсэн дундаж хугацаа 1,102 хоног, дундаж хэмжээ 163.9 сая төгрөг байна. Харин Батлан даалтын чанарыг харвал 11,270 зээлдэгчийн 374.2 тэрбум төгрөгийн батлан даалт хэвийн, 16 зээлдэгчийн 3.6 тэрбум төгрөгийн батлан даалт хугацаа хэтэрсэн, 53 зээлдэгчийн 6.9 тэрбум төгрөгийн батлан даалт чанаргүй ангилалд байна.

Зураг 11 Зээлийн чанар (хувиар)




Зураг 12 Батлан даалтын чанар (хувиар)




2024 оны III улирлын байдлаар нийт батлан даалтад эзлэх чанаргүй батлан даалтын хэмжээ 1.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 дахин бага үзүүлэлт юм. Чанаргүй батлан даалтын хэмжээ нэрлэсэн дүнгээрээ 534.1 сая төгрөгөөр буурахын зэрэгцээ нийт батлан даалтын хэмжээ нэмэгдэж, чанаргүй батлан даалтын тоо жилээс жилд буурсаар байгаа нь батлан даалтын чанарт сайнаар нөлөөлж байна.

Зураг 13 Чанаргүй батлан даалтын хувь, зээлдэгчдийн тоо




Тайлант хугацаанд зээлдүүлэгчдээс чанаргүй 65 зээлийн үүргийг хангуулахаар 8 тэрбум төгрөгийг нэхэмжилсэн ба Зээлийн батлан даалтын сангаас 7.2 тэрбум төгрөгийн үүргийг гүйцэтгэсэн байна. Батлан даалтын үүргийн гүйцэтгэлийн сүүлийн 5 жилийн статистикийг харвал зээлдүүлэгчдээс нэхэмжилсэн дүн болон гүйцэтгэсэн батлан даалтын дүн жилд дунджаар 50-60 хувиар нэмэгдсээр байна.

Зураг 14 Үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын хэмжээ (тэр.төг)



Харин үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын авлагын төлөлтийг харвал 2024 оны эхний гурван улиралд нийт 49 зээлдэгч 1.2 тэрбум төгрөгийг Батлан даалтын санд төвлөрүүлжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71.4 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. 2020-2024 онуудын авлагын мэдээг харвал Батлан даалтын санд төлөгдсөн авлагын дүн жилд дунджаар 2 дахин өсөж, авлагаа төлж буй зээлдэгчдийн тоо жилд ойролцоогоор зургаагаар нэмэгдэж байна. 2024 оны III улирлын байдлаар үүрэг гүйцэтгэсэн батлан даалттай холбоотойгоор нийт 32 зээлдэгчийн 2.4 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Зураг 15 Төлөгдсөн авлагын хэмжээ (тэр.төг)



ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын дагуу Зээлийн батлан даалтын сан нь дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллахаар зохицуулсан байдаг. Үүний дагуу 2024 оны III улирлын байдлаар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг харвал нийт 12 шалгуур үзүүлэлтийг бүгдийг нь хангасан байна.

Хүснэгт 4 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНГААР		ХАНГАСАН ЭСЭХ
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Өөрийн хөрөнгийн байвал зохих хэмжээ	5,000,000,000.00	103,977,033,316.3	Хангасан
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт	10%-аас доошгүй	33.4%	Хангасан
Гаргасан төлбөрийн баталгаа өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй	384,585,604,357.1	Хангасан
ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА			
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	100%-аас доошгүй	112.8%	Хангасан
АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	60%, 100%-аас хэтрэхгүй	100.0%	Хангасан
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	1.2%	Хангасан
Өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40%-аас хэтрэхгүй	0.0%	-
Урт хугацаат өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	2.8%	Хангасан
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	1.2%	Хангасан
НӨӨЦИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Нөөцийн сангийн хүрэлцээний үзүүлэлт /тайлант жилийн цэвэр үр дүнгийн 50%-аас дээш/	7,533,535,039.0	9,649,037,052.6	Хангасан
ЧАНАРГҮЙ БАТЛАН ДААЛТЫН ҮЛДЭГДЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Чанаргүй батлан даалтын үлдэгдлийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	1.8%	Хангасан

САНАЛ, ДҮГНЭЛТ

2024 оны III улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 311.3 тэрбум төгрөгт хүрч, 2023 оны мөн үеэс 20.8 хувиар өссөн бол нийт орлогын хэмжээ 21.6 тэрбум төгрөгт хүрлээ.

Тайлант үеийн хугацаанд шинээр 10,774 зээлдэгчийн 515.1 тэрбум төгрөгийн зээлд 306.3 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн тайлангаар нийт 11,339 зээлдэгчийн 673.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлд 384.8 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэл бүртгэсэн байна.

Тайлант үеийн хугацаанд Улаанбаатар хотын 134 зээлдэгчийн 70.4 тэрбум төгрөгийн зээлд 37.0 тэрбум төгрөгийн, орон нутгийн 10,640 зээлдэгчийн 444.7 тэрбум төгрөгийн зээлд 269.3 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан ба батлан даалтад хамрагдсан зээлдэгчдийн 98.7 хувь нь иргэн, 1.3 хувь нь хуулийн этгээд байна. Улаанбаатар хотын хувьд Баянзүрх болон Хан-Уул дүүргүүдэд хамгийн их буюу нийт 56 зээлдэгчид 21.1 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан бол орон нутагт хангайн бүсэд тэр дундаа Архангай аймагт хамгийн их буюу 1,268 зээлдэгчид 29.1 тэрбум төгрөгийн батлан даалт гаргажээ.

Зээлийн батлан даалтын сангаас 2024 оны III улирлын байдлаар нэр бүхий 8 арилжааны банкны зээлд батлан даалт гаргасан ба үүнээс Төрийн банканд гаргасан батлан даалтын хэмжээ шинээр гаргасан батлан даалтын 66.8 хувийг эзэлж байна. Төрийн банкны хувьд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хоршооны гишүүн малчдад олгосон зээл тухайн банканд гаргасан батлан даалтын 93.1 хувийг бүрдүүлж байна.

Тайлангийн хугацаанд шинээр гаргасан батлан даалтын 77.9 хувь буюу 238.6 тэрбум төгрөгийг “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд төрөөс төсвийн хөрөнгөөр, үлдсэн 22.1 хувийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна.

Батлан даасан зээлийн чанарыг харвал нийт зээлийн багцын 96.6 хувь нь хэвийн, 0.5 хувь нь хугацаа хэтэрсэн, 3.0 хувь нь чанаргүй ангилалд бүртгэгдсэн байна. Харин батлан даалтын чанарыг харвал нийт батлан даалтын 97.3 хувь нь хэвийн, 0.9 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.8 хувь нь чанаргүй ангилалд байна. Хэдий зээлийн болон батлан даалтын чанар сайн байгаа ч цаашдаа мөн зээлийн багцын чанар, ангилал буурсан зээлийн эргэн төлөлт, үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын авлага зэрэгт анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Шинээр батлан даасан зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэлийг харвал батлан даалтын 77.9 хувийг Хоршооны гишүүн малчид, 6.4 хувийг бөөний болон жижиглэн худалдааны бизнес эрхлэгчид, 3.2 хувийг боловсруулах үйлдвэр, үлдсэн 12.5 хувийг бусад төрлийн үйл ажиллагаа эзэлж байгаа нь эдийн засгийн салбаруудад батлан даалтын хүртээмж жигд бус байгааг илтгэж байна. Тиймээс эдийн засгийн бусад салбарт тэр дундаа нэмүү өртөг шингээсэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдэд батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.